



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 1/34

Номгон

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгох тухай

Газрын харилцаа, Геодези зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 10 дугаар зүйлийн 10.17 дахь заалт, Засгийн газрын 2003 оны 205 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Номгон 1-р баг 3-р сургуулийн зүүн талд байрлах иргэн Л.Цэцэгмаагийн 000663293 дугаартай Газар эзэмших эрхийн гэрчилгээг үрэгдүүлсэн тул гэрчилгээг хүчингүй болгосугай.
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосонтой холбогдуулан газар эзэмших эрхийн гэрчилгээг нөхөн олгохыг Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн /С.Должинсүрэн/-д даалгасугай.
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосоныг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг Мэдээлэл технологийн асуудал хариуцсан ажилтан /Ч.Анхбаяр/-т даалгасугай.
4. Үрэгдүүлсэн Газар эзэмших эрхийн гэрчилгээний үнийг 1,5 дахин нэмэгдүүлж төлөхийг иргэн /Л.Цэцэгмаа/-д даалгасугай.

ДАРГА

Т.НОРОВ

